

ГЭМТ хэрэгт татвал зохих хэрэгтнийг бие биедээ шилжуулзн **ӨГЧ** болно.

2. Хэлэлцэн Тохирогч хоёр Зтгээдийн хууль тогтоомжийн дагуу уйлдсэн хэрэгтээ зөвхөн нэг жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэгдсэн ялтны хэргийн таслан шийдвэрлэсэн югтоолыг гуйцэтгэхээр туунийг бие биедээ шилжуулзн өгнө.

ШИЛЖУУЛЭН ӨГӨХӨӨС ТАТГАЛЗАХ

Далан тавдугаар зүйл

Шилжуулэн өгч болохгүй тохиолдол:

а/ хэрэв шилжуулэн өгвөл зохих этгээд шилжуулзн өгөх хусэлтийг хүлээн авч байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн харьяат байвал;

б/ шилжуулэн өгөх шаардлагыг хүлээн авч байгаа Хэлэлцэн Тохирогч Зтгээдийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг уйлдэгдэх уед энэ Гэрээний 71 дүгээр зүйлийн I дэх ангид зааснаар эруугийн хэрэг уусгэх тухай шаардлага гараагүй бол;

в/ шилжуулзн өгөх шаардлагыг хүлээн авч байгаа Хэлэлцэн Тохирогч Зтгээдийн хууль тогтоошкoор эруугийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн буюу шуухийн таслан шийдвэрлэсэн тогтоолыг гуйцэтгэж болохгүй хууль ёсны бусад ундэслэл илэрсэн бол;

г/ Хэлэлцэн Тохирогч нэг Зтгээдийн хууль тогтоомжоор шилжуулэн өгөхийг хориглосон бол;

д/ шилжуулзн өгөх тухай шаардлагыг хүлээн авч байгаа Хэлэлцэн Тохирогч Зтгээдийн нутаг дэвсгэрт шилжуулэн өгвөл зохих этгээдийг уг хэрэгт нь таслан шийдвэрлэсэн тогтоол гаргасан, эсхул мен хэргийг хэрэгсэхгүй болгох тогтоол гаргасан бол.